



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Баримтлах чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.7, 5.2.8 дахь заалт, Сансрын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсад Сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (Х.Энхманлай)-д үүрэг болгосугай.

САЙД



Н.УЧРАЛ

1522017285

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 19 дугаар сарын 26-ны өдрийн
1/93 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД САНСАР СУДЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ



Нэг. Ерөнхий зүйл

1.1. Сансар судлалын техник технологийг хөгжүүлэх, үндэсний хиймэл дагуул хөөргөх, сансрын техник технологийн мэдээллийг боловсруулан ашиглах үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлнэ.

1.2. Энэхүү баримтлах чиглэлийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Сансрын үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагууд Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийг 2023-2033 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3. Энэхүү баримтлах чиглэлд техник, технологийн хөгжил, олон улсын болон үндэсний холбогдох баримт бичгүүдэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор тухай бүрд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хоёр. Хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын орчин

2.1. Сансрын хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлээр дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

2.1.1. олон улсын хэмжээнд өөрийн орны байр суурийг бэхжүүлэн, сансрын уудмыг энхийн зорилгоор ашиглах олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох;

2.1.2. Монгол Улсын сансар судлал, сансар огторгуйн уудам, геомандалын орон зайг ашиглах, сансрын техник технологийг хөгжүүлэх, сансрын хог хаягдлын асуудлыг зохицуулах хуулийн төслийг боловсруулах;

2.1.3. сансар судлал, сансрын технологийн үйл ажиллагаанд ил тод байдлыг эрхэмлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан тэгш оролцоо, чөлөөт өрсөлдөөнийг хангах;

2.1.4. сансар судлал, сансрын технологийн хөгжил болон судалгааны ажлуудад техник, технологи эзэмшигч орны нөлөөлөлд автахаас сэргийлэх, үндэсний чадамжийг түлхүү, оновчтой ашиглаж, үйлдвэрлэлийг дэмжих;

2.1.5. сансар судлалын чиглэлийн техник технологийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, гарааны бизнест хөрөнгө оруулалтыг дэмжих;

2.1.6. Монгол Улсад сансар судлалын асуудлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах төрийн захиргааны байгууллага байгуулах;

2.1.7. сансар судлал, сансрын техник технологийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах.

Гурав. Үндэсний техник технологийн хөгжүүлэлт

3.1. Сансрын үндэсний техник технологийг хөгжүүлэх чиглэлээр дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

3.1.1. дотоодын их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын нөөц бололцоог ашиглан шинжлэх ухаан, технологи, боловсролын зориулалттай бичил ангиллын хиймэл дагуулыг сургалтын зориулалтаар зохион бүтээх, турших, сансрын тойрог замд хөөргөн ашиглах;

3.1.2. Шинжлэх Ухааны Академи, их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага хамтран спектр, орон зайн өндөр нарийвчлал бүхий орчин үеийн мэдрэгчээр тоноглогдсон микро ангиллын зайнаас тандан судалгааны хиймэл дагуулыг зохион бүтээх, турших, сансрын тойрог замд хөөргөн ашиглах;

3.1.3. үндэсний эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн чадавхыг ашиглан гадаадын мэргэжлийн байгууллагуудтай хамтран сансрын холбооны хиймэл дагуулыг Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ОУЦХБ)-аас Монгол Улсад хуваарилсан геостационар орбитын байрлалд хөөргөн ашиглах;

3.1.4. үндэсний пуужингийн технологи хөгжүүлэх, дотооддоо зохион бүтээсэн жижиг, дунд, том оврын пуужин, пуужин хөөргөх технологиор үндэсний болон гаднын орны хиймэл дагуул, ачаа тээшийг сансрын уудамд хүргэх.

Дөрөв. Мэдээллийн боловсруулалт, ашиглалт

4.1. Сансрын мэдээллийг хүлээн авч боловсруулах, ашиглах чиглэлээр дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

4.1.1. Монгол Улсын иргэн, өрх бүрд хямд үнэ, өндөр чанартай өндөр хурдны өргөн зурвасын интернэт болон харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээг газар зүйн байршлаас үл хамааран хүргэх газар сансрыг холбосон үндэсний харилцаа холбооны сүлжээ байгуулах;

4.1.2. байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийн менежментийн газар зүйн мэдээллийн систем бий болгох;

4.1.3. зайнаас тандан судалгааны хиймэл дагуулын зураг, түүнийг боловсруулж үүсгэсэн ортофото зураг, олон сувгийн өгөгдлийг Монгол Улсын газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлд ашиглан олон зориулалттай кадастрын нэгдсэн тогтолцоог бий болгох, газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл, газрын нөөцийн санг байгуулах, газар ашиглалттай холбоотой зөрчил маргааныг илрүүлэх, дүн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.4. Монгол Улсын хэмжээнд сансрын хиймэл дагуулын мэдээллийн бүртгэлийн нэгдсэн санг байгуулах.

Тав. Хүний нөөц

5.1. Сансар судлалын хүний нөөцийг хөгжүүлэх, сурган дадлагажуулах чиглэлээр дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

5.1.1.байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэгтэй, инженерчлэл, техникийн ур чадвартай, сансар судлал, сансрын технологийн чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх бакалавр, магистр, докторын зэргийн хөтөлбөрийг үндэсний их дээд сургуулиудад бий болгох;

5.1.2.сансар судлалын чиглэлээр хөгжингүй улс оронд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх.

Зургаа. Гадаад хамтын ажиллагаа

6.1.Сансрын гадаад хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх чиглэлээр дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

6.1.1.Сансрын нисэгчийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

6.1.2.Сар, Марс болон сансрын биетийн судалгааг хөгжүүлэх олон улсын хөтөлбөрт хамрагдах;

6.1.3.олон улсын болон бусад улсын сансрын станц дээр хийгдэж байгаа судалгаа шинжилгээний ажилд оролцох;

6.1.4.олон улсын сансрын хамтын ажиллагааны байгууллагуудад гишүүнээр элсэх.

Долоо. Сургалт, сурталчилгаа

7.1.Сансар судлалын шинжлэх ухааныг нийгэмд сурталчлан таниулах чиглэлээр дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

7.1.1.Монгол Улсад “Олон улсын сансрын 7 хоног” болон “Сансар судлалын өдөр”-ийг уламжлал болгон зохион байгуулах;

7.1.2.Шинжлэх Ухааны Академийн Астропаркийн үзүүлэн, үзмэр, багаж тоног төхөөрөмжийг шинэчлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, одон орон, сансар судлалын шинжлэх ухааны ололт амжилтыг олон нийтэд таниулан сурталчлах;

7.1.3.олон нийтийн танин мэдэхүй, шинжлэх ухааны боловсролд зориулсан Шинжлэх ухааны төв (Science PARK) байгуулах;

7.1.4.сансар судлал, сансрын технологийн чиглэлээр хүүхдийн зуслан ажиллуулах, сурагч оюутнууд, олон нийтийг хамарсан уулзалт, лекц семинар, дугуйлан, мэргэжлийн курс, гадаад дотоодын сансрын технологийн тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулах.